



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/07

Чингис хот

Авто машин хүлээж авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газарт Цагдаагийн газраас шилжүүлж байгаа Ланд круйзер 200 маркын автомашиныг хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Э.Ариунтунгалаг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч
Гишүүд:	Т.Баяржаргал	-Нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-ын Захирал
	Л.Нямдорж	-Нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-ын механикжуулагч, жолооч
	С.Сарангоо	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

2. Автомашиныг шилжүүлж хүлээж авах, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгөхийг комиссын дарга С.Нямдаваад даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР